



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 09 сарын 24 өдөр

Дугаар А/603

Булган сум

“Macau cadet Asian cup 2025” жүдо бөхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох өсвөрийн тамирчинд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.7 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардал батлах тухай” А/360 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Макао улсад 2025 оны 07 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулагдах “Macau cadet Asian cup 2025” жүдо бөхийн аварга шалгаруулах тэмцээнд аймаг, орон нутгаа төлөөлөн оролцох өсвөрийн тамирчин Н.Мягмарнарангийн замын зардалд 1,952,000 (нэг сая есөн зуун тавин хоёр мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг “Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

6325010926

Сугаг Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж